БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 05 өдөр Дугаар А/747 Булган сум

Гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны аравдугаар хуралдааны Х/16 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Аймгийн Хөгжимт жүжгийн театрт шаардлагатай бүжигчид, дуучдын хувцас хэрэглэл хийж гүйцэтгэх төсөл арга хэмжээг батлагдсан төсөвт өртөг 15,000,000 (арван таван сая) төгрөгт багтаан хууль, журмын дагуу зохион байгуулан чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авах эрхийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Халиунаа)-д олгосугай.

2.Гэрээнд заасан барааг холбогдох хууль, журам, стандартын дагуу хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг "Тэргүүн агт" ХХК (Д.Энхбаяр)-д даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааны явцад мэргэжлийн зөвлөгөө өгч, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Соёл урлагийн газар (Г.Алдармөнх)-т даалгасугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу 2022 оны аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгдсөн арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5. Дээрхи дуучид, бүжигчдийн хувцас хэрэглэлийг байгууллагын данс бүртгэлд баталгаажуулан бүртгэж хүлээн авахыг Аймгийн Хөгжимт жүжгийн театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Халиунаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

АБХЭ-everyday Doc/2022/Захирамж

6322011041